

**4 дүгээр ангийн анги дэвших монгол хэл, хүн ба байгаль хичээлийн  
нэгдмэл шалгалтын сэдэв**

**ХУВИЛБАР- А**

Сурагч .....

Хугацаа – 60 мин

**Нэгдүгээр хэсэг:** Унших чадвар

**Буга**

Буга ус уухаар гол ээр ирж, өөрийнхөө усанд туссан дүрсийг харан том даргар эврээрээ бахархан, хөлөө харж:

-Миний хөл даанч турьгүй, нарийхан, доожоогүй юм гэж үглэж байв.

Гэнэт арслан гарч ирэн, буга руу дайрав. Буга уужим талаар хар хурдаараа зугтаж баригдалгүй явснаа ойд ормогц эвэр нь модонд тээглэн орооцолдож, арсланд баригдчихжээ.

Буга амь үрэгдэхийн даваан дээр “Ямар хачин юм бэ? Би эврээ ямар гоё юм бэ? гэж бахдаж байсан юм сан. Голж байсан нарийхан хөл минь аюулаас аварч, бахдан дэнхгэнүүлж байсан даргар эвэр маань намайг аюулд унагадаг байна шүү. Аливаа юмыг үзэгдэх хэлбэр, өнгөөр нь үнэлж болдоггүй юм байна” гэж бодов.

1. Бугаар ямар хүний зан чанарыг үзүүлсэн гэж бодож байна вэ?

А. доожоогүй

Б. голомтгой

В. гунигтай

2. Бугын хийсэн үйл хөдлөл аль нь вэ?

А. Эврээ гайхуулсан

Б. Эврээрээ бахархсан

В. Эврээ унагасан

3. Буга аюулд орох үедээ юуг ухаарсан бэ?

.....  
.....

4. Ихэмсэг гэдэг үгийн эсрэг утгыг олоорой.

А. хүлцэнгүй

Б. ноомой

В. бардам

5. Дараах үгийн утгыг тайлбарлан бичээрэй.

Бүрх - .....

6. Зөв бичсэн үгсийг олж дугуйлаарай.

А. мориноос, оролцоё, урагшил, эмээллэе

Б. морьноос, оролцъё, урагшал, эмээллэе

В. мориноос, оролцъё, урагшил, эмээллэе

Хоёрдугаар хэсэг.Задгай даалгавар

7. Дараах үгсийн хатуугийн тэмдгийг зөөлний тэмгээр сольж үүссэн үгээр нь утгыг гарган өгүүлбэр зохион бичээрэй.

уръя - .....


соръё - .....



## ХҮН БАЙГАЛЬ

1. Дараах өгөгдлөөс “гадаад араг” ястай амьтны нэрийг сонгоно уу. /1 оноо /  
А. арслан                      В. чоно                      С. эмгэн хумс                      D. адуу
2. Дараах зурагт өгөгдсөн 5 дугаарт харгалзах нэрийг сонгоно уу. / 1 оноо /


урдаас хажуугаас



сээр нуруу

- A. ахар сүүл
- B. бүсэлхий
- C. сээр
- D. хүзүү

3. Булчин хүний биеийн араг яснуудад бэхлэгдсэн байдаг. Эдгээр булчингийн гүйцэтгэх үүрэг юу вэ?  
А. Булчин ясыг хөдөлгөдөг.                      В. Булчин ясыг хоол тэжээлээр хангадаг  
Б. Булчин ясыг хамгаалдаг.                      Г. Булчин ясанд дохио дамжуулдаг
4. Нарны гэрлийг хэд хэдэн толины тусламжтайгаар нэг газар цуглуулаад удаан тусгавал ямар өөрчлөлт гарах вэ?  
А. Гэрэл тод харагдана                      Б. Гэрэл бүдэг болно                      В. Халуун мэдрэгдэнэ
5. Зурагт өгөгдсөн соронзын харилцан үйлчлэлийг сонгоно уу. / 1 оноо /



- A. ижил туйл учир таталцана
- B. ижил туйл учир түлхэлцэнэ
- C. эсрэг туйл учир таталцана
- D. эсрэг туйл учир түлхэлцэнэ

6. Цэгийн оронд тохирох үгийг сонгон өгүүлбэрийг гүйцээнэ үү. Бие гэрэл үүсгэгч рүү ойртох тусам сүүдрийн ..... / 1 оноо /  
А. хэлбэр нь өөрчлөгдөнө                      В. дүрс нь тодорно  
С. хэмжээ нь багасна                      D. хэмжээ нь томорно
7. Сарвууны яс ямар, ямар хөдөлгөөн хийдэг вэ? Нөхөж бичээрэй /3 оноо/  
Гарыг атгах, ....., ....., .....  
чимхэх зэрэг хөдөлгөөн хийдэг.
8. Орхигдсон үгийг нөхөж бичээрэй. /3 оноо/  
Өвдөгний үе нь хөл дээр ....., ....., .....  
тулгуур болж өгдөг.
9. Бодисын төлөв байдлын өөрчлөлтийг харгалзуулан холбоорой.  
1. Хатуу бодис шингэн төлөвт шилжих                      А. Царцах  
2. Шингэн бодис хатуу төлөвт шилжих                      В. Уурших  
3. Шингэн бодис хийн төлөвт шилжих                      С. Хайлах

**4 дүгээр ангийн анги дэвших монгол хэл, хүн ба байгаль хичээлийн  
нэгдмэл шалгалтын сэдэв**

**ХУВИЛБАР- Б**

Сурагч .....

Хугацаа – 60 мин

**Нэгдүгээр хэсэг:** Унших чадвар

**Ёгт үлгэр**

Тогос, богширго хоёр нэг өдөр ойд тааралдаж гэнэ. “Чи бол өрөвдөлтэй, азгүй, жижигхэн, саарал өнгөтэй” гэж тогос хэлээд “Над шиг баян, сэтгэл татам, өнгөлөг, том болмоор байна уу?” гэж асууж гэнэ. “Үгүй, би өөрөө өөртөө сэтгэл хангалуун байдаг” гэж богширго хариулав

Гэтэл нэгэн орой бүргэд хоол хайн, тэдний дээгүүр эргэлдэж эхэлж гэнэ. Богширго жижигхэн, туранхай болохоор нэгэн мод руу нисэн орж халхлагдаж чаджээ. Тогос ч нуугдахыг хичээж, нисэх гэсэн боловч өд сөд нь дэндүү хүнд дэндүү өнгөлөг болохоор бүргэд түүнийг дор нь олж хараад нисэн ирж, шүүрээд явчихжээ.

1. Тогосоор ямар хүний зан чанарыг үзүүлсэн гэж бодож байна вэ?

А. залхуу

Б. биеэ тоосон

В. шударга

2. Тогосын гаргасан үйлдэл аль нь вэ?

А. өөрийгөө гоёсон

Б. өөрөөрөө бахархсан

В. өөрийгөө халхалсан

3. Тогос аюулд орох үедээ юуг ухаарсан бэ?

.....  
.....

4. Ихэмсэг гэдэг үгийн ойролцоо утгыг олоорой.

А. хүлцэнгүй

Б. ноомой

В. бардам

5. Дараах үгийн утгыг тайлбарлан бичээрэй.

Ган гачиг - .....

6. Зөв бичсэн үгсийг олж дугуйлаарай.

А. танилаар, хамгаалая, батламжал, хооллоё

Б. танилаар, хамгаалъя, батламжил, хооллоё

В. таньлаар, хамгаалъя, батламжил, хооллъё

Хоёрдугаар хэсэг.Задгай даалгавар

7. Дараах үгсийн зөөлний тэмдгийг хатуугийн тэмгээр сольж үүссэн үгээр нь утгыг гарган өгүүлбэр зохион бичээрэй.

урья - .....

сорьё - .....

тарья - .....

8. Хэлц үгсийн утгын тайлбарыг тохируулан холбоод, өгүүлбэр зохиогоорой.




## ХҮН БАЙГАЛЬ

1. Дараах өгөгдлөөс “дотоод араг” ястай амьтны нэрийг сонгоно уу. /1 оноо /  
A. арслан                      B. дун                      C. эмгэн хумс                      D. царцаа
2. 2 дугаартай зурагт тохирох тайлбарыг сонгоно уу. / 1 оноо /



- A. буруу суухад, эгц алхахад
  - B. зөв суухад, тонгойж алхахад
  - C. буруу суухад, тонгойж алхахад
  - D. зөв суухад, эгц алхахад
3. Хүний биеийн араг яс нь биеийн тулгуураас гадна ямар үүрэгтэй вэ?  
A. Дотор эрхтнүүдийг хамгаалах, биеийг хөдөлгөх  
B. Нуруу, сээрийг хөдөлгөх үүрэгтэй  
C. Үе мөчийг хөдөлгөх үүрэгтэй  
D. Толгойг хамгаалж, биеийг хөдөлгөх.
  4. Компьютерийн дэлгэцэнд соронзыг ойр байрлуулж болохгүй хамгийн чухал шалтгааныг сонгоно уу. / 1 оноо /  
A. Дэлгэцийг гэмтээж дүрсний хэлбэр өөрчлөгдөнө.  
B. Дэлгэцийг гэмтээж өнгө ялгарал муудна.  
C. Дэлгэц томорно.  
D. Дэлгэц шатна.
  5. Соронзны S ба N нь ..... туйл юм.  
A. таталзах                      B. эсрэг                      C. түлхэлцэх                      D. ижил
  6. Зурийг ажиглаад зөв хариултыг сонгоорой.



- A. Нэг гэрэл үүсгэгчтэй
  - B. Хоёр гэрэл үүсгэгчтэй үед
  - C. Хоёр сүүдэр давхардсан үед
7. Ямар, ямар хэсгээс бүрддэг болохыг нөхөж бичээрэй.  
Хүний сээр, нуруу нь ....., ....., ....., ууц, ахар сүүл гэсэн хэсгүүдээс тогтдог.
  8. Орхигдсон үгийг нөхөж бичээрэй. /3 оноо/  
Өвдөгний үе нь яснуудыг холбогч .....,  
..... -нээс тогтоно.
  9. Зөв харгалзуулан холбоорой.  
1. Хатуу                      A. Савныхаа хэлбэрийг хадгалдаг  
2. Хий                      B. Маш нягт эмх цэгцтэй  
3. Шингэн                      C. Эмх замбараагүй чөлөөтэй хөдөлдөг